

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч, Адъяа Мөнхсайхан

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах, төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, төслийн бүрэн шинжилгээг хянах, дүгнэх, төслийн сонгон шалгаруулалт болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, түншлэлээр хэрэгжсэн төслийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг удирдан зохион байгуулах							
1	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагалдан гарах журам, аргачлалд заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хэрэгжилтийн явц, хувиар	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.	Холбогдох журам, аргачлалд заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажилласан байна. /100 хувь/	- Эрчим хүчний сайдаас 2025 оны а/391 дугаар албан бичгээр ирүүлсэн “Байдрагийн усан цахилгаан станц” төслийн саналыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон дагалдан гарсан журам, аргачлалд заасны дагуу хүлээн авч, тухайн төслийн урьдчилсан үнэлгээг хийлгэхээр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт тус яамны 2025 оны 03/419	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					дугаар албан бичгийг холбогдох материалын хамт хүргүүлсэн. Тус төвөөс тухайн төслийн урьдчилсан үнэлгээний санал, дүгнэлтийг гарган ирүүлснээр төслийн бүрэн шинжилгээг хийх боломжтой болсон. Хууль болон дагалдан гарсан журам, аргачлалд заасны дагуу Эрчим хүчний яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон холбогдох байгууллагуудаас төслийн бүрэн шинжилгээ хийх төслийн багт ажиллах албан хаагчдын нэрсийг аван, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/120 дугаар тушаалаар бүрэн шинжилгээ хийх төслийн багийг байгуулсан. Тус төслийн бүрэн шинжилгээ хийх төслийн багийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, холбогдох журмын талаар төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн зарим албан тушаалтнуудад тогтмол мэдээллийг хуулийн хүрээнд өгч ажиллаж байна.		
--	--	--	--	--	--	--	--

2	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон тус хуулийг дагалдан гарсан журам, аргачлалын хүрээнд сургалтыг зохион байгуулна.	Зохион байгуулах сургалтын тоо	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.	Холбогдох байгууллагуудад нийт 3-аас доошгүй удаа сургалт орсон байна. /3 сургалт/	Эдийн засаг, хөгжлийн яам, Азийн хөгжлийн банк болон "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар хамтран Төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин болон Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар сурталчлах, танилцуулах, санал солилцож, хэлэлцэх зорилго бүхий "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум"-ыг 2025 оны 03 дугаар сарын 13-ын өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан. Энэхүү форумд Элчин сайдын яамд, олон улсын байгууллагууд, дотоод, гадаадын хувийн хэвшил, хөрөнгө оруулагчид, олон нийтийн байгууллага болон төрийн байгууллагуудын 250 гаруй зочид, төлөөлөгчид оролцсон.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр салбар яамдаас ирүүлсэн саналыг	Хэрэгжилтийн явц, хувиар	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 сарын 01-	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр салбар яамдаас ирүүлсэн саналыг	- "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам төсөл", "Байдрагийн усан цахилгаан станц төсөл"-ийн бүрэн шинжилгээ хийх	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар	100%

	ТХХТ-ийн хуульд заасны дагуу судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллана.		ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.	ТХХТ-ийн хуульд заасны дагуу судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллана. /100 хувь/	төслийн багийн бүрэлдэхүүнд орж ажилласан. - "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны 25/61 дугаар албан бичгээр "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам төсөл"-ийн бүрэн шинжилгээ хийх хугацааг сунгах хүсэлтийг ирүүлснийг судлан, Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны 03/1420 дугаар албан бичгээр төслийн бүрэн шинжилгээ хийх хугацааг холбогдох үндэслэлээр сунгах боломжгүй талаар хариу албан бичиг хүргүүлсэн. - Эрчим хүчний сайдаас 2025 оны а/391 дугаар албан бичгээр ирүүлсэн "Байдрагийн усан цахилгаан станц" төслийн саналыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон дагалдан гарсан журам, аргачлалд заасны дагуу хүлээн авч, тухайн төслийн урьдчилсан үнэлгээг хийлгэхээр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт тус	сар, сар, сар, сар, сар	8-р 9-р 10-р 11-р 12-р	
--	---	--	--	--	--	-------------------------------------	------------------------------------	--

					яамны 2025 оны 03/419 дугаар албан бичгийг холбогдох материалын хамт хүргүүлсэн. Тус төвөөс тухайн төслийн урьдчилсан үнэлгээний санал, дүгнэлтийг гарган ирүүлснээр төслийн бүрэн шинжилгээг хийх боломжтой болсон. Хууль болон дагалдан гарсан журам, аргачлалд заасны дагуу Эрчим хүчний яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон холбогдох байгууллагуудаас төслийн бүрэн шинжилгээ хийх төслийн багт ажиллах албан хаагчдын нэрсийг аван, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/120 дугаар тушаалаар бүрэн шинжилгээ хийх төслийн багийг байгуулсан.		
4	Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин ажиллаж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.	Хэрэгжилтийн явц, хувиар	Концессын гэрээний хэрэгжилтийн явцад тухай бүр хяналт тавьсан.	Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин ажиллаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. /100 хувь/	Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин, тухай бүр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. - Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төсөл: 1. Тус яамны 2025 оны 03/928 дугаар албан бичгээр "Төслийн авто	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт"-ийг Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Үүний дагуу Зам, тээврийн яамнаас 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр холбогдох зөвшөөрлийг сунгасан.2. Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 01/1288 дугаар албан бичгээр "Төслийн ажлыг хэвийн явуулах боломжоор ханган, хууль тогтоомж болон концессын гэрээний хүрээнд орон нутгаас олгогдох шаардлагатай зөвшөөрлүүдийг олгон, дэмжлэг үзүүлэн ажиллах" агуулга бүхий хүсэлтийг Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбатад хүргүүлсэн. - Зүүнбаян- Ханги чиглэлийн төмөр зам төсөл: Концесс эзэмшигч "Монголиантранс лайн" ХХК-ийн 2025 оны 202 дугаар албан бичгээр "... төмөр замаар хил холбогдох асуудал тодорхойгүй байгаа одоогийн нөхцөлд	
--	--	--	--	--	--	--

					компани санхүүгийн хувьд хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байгаа тул концессын гэрээний 25.1.1-д заасан дагуу төслийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт, санхүүгийн зардал болон ирээдүйд олох ашгийг манайд олгож, төмөр замын суурь бүтцийг төрийн өмчлөлд авах" агуулга бүхий хүсэлт ирүүлснийг судлан, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 01/1557 дугаар албан бичгээр хууль тогтоомж болон концессын гэрээний хүрээнд холбогдох хариуг хүргүүлсэн. - Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төсөл, Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км авто зам төсөл болон Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам төслийн хэрэгжилтийн явцын мэдээ, тайланг тогтмол авч ажилласан.		
--	--	--	--	--	---	--	--

5	Монгол Улсын 2025 оны төсөвт батлагдсан концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлсэн төслүүдийн санхүүжилтийг хууль, гэрээ, аудитын дүгнэлтэд нийцүүлэн шийдвэрлэнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	Монгол Улсын 2025 оны төсөвт 1 төслийн санхүүжилт батлагдсан.	Улсын төсөвт батлагдсан санхүүжилтийг хууль, гэрээ, аудитын дүгнэлтэд нийцүүлэн шийдвэрлэсэн байна. /100 хувь/	Монгол Улсын Дээд шүүхийн Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 001/ХТ2024/00103 дугаар тогтоолоор нэхэмжлэгч "Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концесс эзэмшигч "Макс рөүд" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, Засгийн газраас 10,928,624,101 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжид 54,801,071 төгрөг, нийт 10,983,425,172 төгрөгийг гаруулахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтад тухайн төслийн санхүүжилт 10,983.5 сая төгрөг тусгагдсаныг Эдийн засаг, хөгжлийн яамнаас тухайн төслийн концесс эзэмшигч "Макс рөүд" ХХК-д олгосон.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
6	Нэгжийн эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн	Хэрэгжилтийн явц, хувиар	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ Засгийн газрын	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагааг бодлогоор	- Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/16 дугаар тушаалаар "Түншлэлийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хяналт тавих		2024 оны 23 дугаар тогтоолоор байгуулагдаж, үйл ажиллагаа эхэлсэн.	зохицуулж, чиглүүлж хяналт тавьсан байна. /100 хувь/	төсөл хөгжүүлэх сангийн бодлого, стратегийг тодорхойлох, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, сангийн тухайн жилийн төсөв, төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг хянах, сангийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус удирдах хороо"-г байгуулсан. - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагаатай холбоотойгоор тус төвийн албан хаагчдыг хууль тогтоомжийн хүрээнд тогтмол мэдээллээр ханган ажиллаж байна.	сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							

1	Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна.	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцох.	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон.	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна. /100 хувь/	JICA олон улсын байгууллагаас "Төсвийн зохистой удирдлагад чиглэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн менежментийн чадавх бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд зохион байгуулсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн эрсдэлийн удирдлага" сургалтад 2025 оны 06 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд цахимаар оролцсон.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Хувь хүний хөгжил болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалт, семинар, хөтөлбөрт хамрагдсан байна.	Мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалт, семинар, хөтөлбөрт хамрагдах.	Мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалт, семинар, хөтөлбөрт хамрагдсан.	Мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалт, семинар, хөтөлбөрт хамрагдсан байна. /100 хувь/	Яамнаас зохион байгуулж буй мэдээллийн цагт тогтмол хамрагдаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр Огноо: 2025.06.25

ТАЙЛАН ГАРГАСАН:

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч А.Мөнхсайхан Огноо: 2025.06.25